

МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

№ 21/1

Улаанбаатар хот

Мөнгөний бодлогын хороо (МБХ) 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдөр хуралдаж, хуралдааныг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн удирдав. Хуралдаанаар МБХ-ны гишүүд мөнгөний бодлого болон банкны салбарын төлөв байдлын танилцуулгыг сонсож, бодлогын хүү, Төв банкны репо санхүүжилтийн нөхцөлийн талаар хэлэлцлээ.

МБХ-ны хуралдааны эхний хэсэгт Мөнгөний бодлогын газар болон Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газар (ББӨБГ)-аас банкны системийн өнөөгийн нөхцөл байдлын талаар дэлгэрэнгүй танилцуулга хийв.

Банкны системийн актив КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор 2020 оны эхнээс тасралтгүй агшиж, 2020 оны 6 дугаар сараас эхлэн аажим өсч эхэлсэн ч 2021 оны 1 дүгээр сард 2020 оны эцсээс 0.6 хувиар буюу 229.9 тэрбум төгрөгөөр агшсан байна. Мөн цар тахлын нөлөөгөөр банкууд баланс дахь эрсдэлээ бууруулж, эрсдэл багатай үнэт цаас дахь хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлсэн байна.

Эх үүсвэрийн жилийн өөрчлөлт 2021 оны 1 дүгээр сарын байдлаар 4.0 хувь гарсан бөгөөд үүнд хадгаламж өмнөх оны мөн үеэс 31.5 хувиар өссөн нь голчлон нөлөөлжээ. Хадгаламжийн дансны өсөлтөд 1) бүх нийтийн хөл хорио тогтоосноор иргэдийн хүнсний бус хэрэглээний зардал буурсан; 2) төрөөс цахилгаан, дулаан ашиглалтын зардлыг хөнгөлсөн; 3) ханшийн өсөлтөөс шалтгаалсан валютын хадгаламжийн өсөлт, харилцах данснаас хадгаламжийн данс руу шилжсэн; 4) КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор зээлийн төлбөрийг хойшлуулсан Монголбанкны шийдвэр зэрэг нь нөлөөлсөн байх боломжтой гэж үзжээ.

ББӨБГ-ын зүгээс банкны систем 2021 оны 01 дүгээр сарын байдлаар 282.8 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж байгааг танилцуулав. Банкны ашигт ажиллагааны үзүүлэлт болох цэвэр ашиг, нийт активын харьцаа (ROA) тайлант оны эцэст харгалзан -9.4 хувь байна. Мөн нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа 14 орчим хувьтай гарчээ.

Үргэлжлүүлээд, санхүүгийн системийн эрсдэлийн зураглалыг танилцуулсан бөгөөд санхүүгийн системийн орчныг авч үзвэл макро эдийн засгийн орчин хамгийн ихээр муудсан байгаа бол банкны салбарын нийт ашигт ажиллагаа,

төлбөрийн чадварын эрсдэлийн үзүүлэлтүүд анхааруулах дохио өгч байгаа болохыг онцлов. Улмаар банкны системд учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх, гарч болзошгүй сөрөг үр дагаврыг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй зохицуулалтын арга хэмжээний үр нөлөө, түүний үргэлжлэх хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон дуусгавар болох үед хэрхэн цуцлах, холбогдох зохицуулалтуудыг хэвийн горимд шилжүүлэх хувилбар, төлөвлөгөөний саналыг боловсруулж байгааг танилцуулав.

МБХ-ны хуралдааны дараагийн хэсэгт макро эдийн засгийн өнөөгийн болон ирээдүйн төлөв, санхүүгийн зах зээл, гадаад, дотоод орчинд гарч буй гол өөрчлөлтүүд, КОВИД-19 вирусын тархалттай холбоотой эдийн засагт үүсч болзошгүй эрсдэлийг Монголбанкны Мөнгөний бодлогын газар (МБГ)-аас танилцууллаа.

МБГ-ын зүгээс инфляцад үзүүлэх эрэлт, нийлүүлэлтийн хүчин зүйлсийн нөлөө ирэх саруудад нэмэгдэх хүлээлтэй байгаа болохыг танилцуулав. 2021 оны 2 дугаар сард инфляц улсын хэмжээнд 2.6 хувь, Улаанбаатар хотод 2.0 хувьд хүрлээ. Махны үнэ 2-р сард улирлын хандлагаасаа давж өссөн ч сайжруулсан түлшний үнийг 75 хувь хөнгөлсөн нь инфляц 1-р улирлыг дуустал бага гарахад нөлөөлөхөөр байна. Харин 2-р улирлаас нийлүүлэлтийн шалтгаантай инфляц нэмэгдэхэд; 1) шатахууны үнийн суурь үеийн нөлөө арилах, 2) сайжруулсан түлшийг хөнгөлөлттэй үнээр худалдаалах Засгийн газрын шийдвэрийн хэрэгжих хугацаа 4-р сарын 1-ний өдрөөр дуусгавар болох нь голлон нөлөөлөхөөр байна. Эрэлтийн хүчин зүйлсийн хувьд инфляцад үзүүлэх нөлөө нь эдийн засгийн идэвхжилийг даган аажмаар нэмэгдэх хандлагатай байна. Цаашид нийлүүлэлтийн шалтгаантай үнийн огцом хэлбэлзэл үүсэхгүй гэж үзвэл 2021 онд инфляц төв банкны зорилтот түвшний орчимд ($6\% \pm 2\%$) хадгалагдах хүлээлттэй байгааг танилцуулав.

Энэ оны эдийн засгийн өсөлт өмнөх төсөөллийн орчимд байгаа болохыг МБГ-аас танилцууллаа. Тодруулбал, эрдэс бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэнээр уул уурхайн салбар эрчимжихээр байгаа бол цар тахлын сөрөг нөлөө уул уурхайн бус салбарт хүлээлтээс өндөр байхаар байна. Улаанбаатар хотод вирусын тархалт нэмэгдэж 2021 оны 2-р сард бүх нийтийн бэлэн байдалд шилжин, хатуу хөл хорионы дэглэм тогтоосон нь 1-р улирлын уул уурхайн бус салбарын өсөлтийг сааруулах нөлөөтэй. Түүнчлэн, КОВИД-19-ийг бүрэн хяналтад оруулах хугацаа удааширч, тархах хүрээ нь тэлж байгаа тул энэ оны 2-р улиралд уул уурхайн бус салбар хэвийн түвшинд хүрч сэргэхээргүй байна.

Уул уурхайн салбарын хувьд хилийн бүс нутгуудад халдвар тархахгүй, экспорт хэвийн явагдах тохиолдолд тус салбар 2021 онд өндөр өсөлттэй байх төлөвтэй болохыг онцлов. Эдийн засгийн цаашдын төлөв хэрхэн өөрчлөгдөх нь дотоодод тархсан КОВИД-19 вирусыг хяналтдаа оруулах хугацаанаас голлон хамаарч байгааг анхааруулав.

МБГ-ын зүгээс төсвийн гүйцэтгэл, төсөөллийг танилцууллаа. Төсвийн нийт орлого энэ оны эхний 2 сард өмнөх оны мөн үеэс 256 тэрбум төгрөгөөр (17 хувиар) нэмэгджээ. Үүнд, аж ахуй нэгжийн ОАТ, НӨАТ, тогтворжуулалтын сантай холбоотой орлого нэмэгдсэн нь төсвийн орлого нэмэгдэхэд нөлөөлөв. Төсвийн нийт зардал эхний 2 сард өмнөх оны мөн үеэс 254 тэрбум төгрөгөөр (17 хувиар) нэмэгдсэн байна. Төсвийн тэнцлийг энэ онд батлагдсан түвшинд байхаар авч үзжээ.

M2 мөнгө 2021 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 18 хувиар (3.7 их наяд төгрөгөөр) өсчээ. Үүнд актив талаас Засгийн газрын цэвэр зээл буюу Засгийн газраас банкны системийн авах цэвэр авлага 1.3 их наяд төгрөгөөр, гадаад цэвэр актив 2.2 орчим их наяд төгрөгөөр нэмэгдсэн нь өсөлтийг голлон тайлбарлаж байна. Мөн эх үүсвэрийн долларжилт тогтворжиж байгаа болохыг МБГ-ын зүгээс дурдав.

Банкны системийн зээл олголт болон эргэн төлөлтийн талаар дэлгэрэнгүй танилцуулав. Банкны системээс 2020 онд нийт 19.8 их наяд төгрөгийн зээл олгосон бөгөөд энэ нь 2019 оноос 6 хувиар буурсан үзүүлэлт юм. Банкны системийн зээлийн эргэн төлөлт 2020 онд 20.5 их наяд төгрөг, харин тэтгэврийн зээл тэглэсэн нөлөөг хасч тооцвол 19.8 их наяд төгрөг байна. 2021 оны 1 дүгээр сарын байдлаар банкны системээс 1.4 их наяд төгрөгийн зээл олгосон байгаа бол зээлийн эргэн төлөлт мөн 1.4 их наяд төгрөг байна.

Зээл, хадгаламжийн хүү буурч байна. 2017-2019 оны хооронд хадгаламж, зээлийн хүү буурсан нь макро эдийн засгийн тогтвортой байдалтай холбоотой бол 2020 оноос буурч байгаа нь бодлогын хүү, заавал байлгах нөөц болон репо санхүүжилттэй холбоотой гэж үзжээ.

Танилцуулгаар чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн нийт дүн 3.3 их наяд төгрөгт хүрсэн болохыг онцлов. Энэ нь түүхэн дээд түвшин бөгөөд нийт зээлийн багцын 19.4 хувийг бүрдүүлж байгаа нь санхүүгийн зах зээлд эрсдэл хуримтлагдаж байгааг илтгэж байна.

Үргэлжлүүлээд, МБГ-ын зүгээс дэлхий нийтээр цар тахлын эсрэг вакцинжуулалт эхэлж, гадаад орчинд эерэг өөрчлөлтүүд ажиглагдаж байгааг танилцуулав. Томоохон эдийн засагтай орнуудын 2020 оны 4-р улирлын эдийн засгийн өсөлт хүлээлтээс өндөр гарсны дээр БНХАУ, АНУ-ын 2021 оны өсөлтийн төсөөлөл нэмэгдлээ. Хэдийгээр гадаад орчинд цар тахлын шинэ давлагаанууд үүсч дэлхийн эдийн засгийн идэвхжилд сөргөөр нөлөөлж байгаа боловч тархалтыг хяналтад оруулах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх чадамж нэмэгдэж байгаагийн зэрэгцээ эдийн засгийн сэргэлтийн хүлээлт харьцангуй өөдрөг хэвээр байна. Цаашид КОВИД-19 вирусын эсрэг вакцины хүрэлцээ, үйлдвэрлэлийн чадамж, вакцинжуулах хурд зэргээс гадаад эрэлтийн ерөнхий төлөв хамаарахаар байгааг дурдав. Мөн гадаад худалдааны нөхцөлийн төсөөлөл 2021 онд өмнөх төсөөллөөс сайжирсан бөгөөд үүнд зэс, нүүрс, төмрийн хүдрийн экспортын үнийн төсөөлөл нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

МБГ-ын зүгээс төлбөрийн тэнцэл 2021 онд 470 орчим сая ам.долларын ашигтай гарах төлөвтэй байгааг танилцуулав. Төлбөрийн тэнцлийн төсөөллийг өмнөхөөс бууруулахад ГШХО болон донор санхүүжилт буурах нь голлон нөлөөлөв. Харин экспортын үнүүд өсч, энэ нь экспортын орлогын төсөөллийг өсгөх чиглэлд нөлөөллөө. Энэ оны төлбөрийн тэнцлээс Оюу толгойн төлбөрийн тэнцэлд үзүүлэх цэвэр нөлөөг хасч тооцвол төлбөрийн тэнцэл 1.1 тэрбум ам.долларын алдагдалтай гарахаар байгааг онцоллоо.

Ийнхүү Мөнгөний бодлогын газраас бодлогын хүүг 0.5 нэгж хувиар бууруулж, 5.5 хувьд хүргэх санал гаргасныг МБХ-ны гишүүд хэлэлцлээ.

КОВИД-19 цар тахлын тархалт үргэлжилж, хорио цээрийн арга хэмжээ чангарах, вакцинжуулалт удаашрах зэрэг нөхцөл байдал үүсвэл бодлогын хүү буурсан ч эдийн засгийг дэмжих нөлөө нь хязгаарлагдана. Иймд вирусын тархалттай холбоотой тодорхой бус байдал өндөр байгаа одоогийн нөхцөлд банкны салбарт учрах санхүүгийн дарамтыг нэмэгдүүлэхгүй байх үүднээс бодлогын орон зайг тодорхой түвшинд хадгалж, цаашид эдийн засгийн нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөхөөс хамааран бодлогын тохируулгыг хийх нь зүйтэй гэж МБХ-ны зарим гишүүд үзэв. Түүнчлэн, дотоодын халдвар эрчтэй нэмэгдэж байгаатай холбоотойгоор хатуу хөл хорио дахин тогтоох нөхцөлд хүнсний зарим бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлт тасалдаж, инфляц хүлээлтээс хурдтай өсөхөөс гадна МУЗГ-аас хэрэгжүүлж буй “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх төлөвлөгөө”-ний хүрээнд хэрэглээ, хөрөнгө оруулалтын бараа бүтээгдэхүүний импорт нэмэгдэж, төгрөгийн ханшид ирэх

дарамт нэмэгдэх зэрэг эрсдэл үүсч болзошгүй тул бодлогын хүүг энэ удаад хэвээр хадгалах нь зүйтэй гэсэн байр суурийг МБХ-ны гишүүд илэрхийллээ.

Харин өөр нэг гишүүний хувьд инфляцад үзүүлэх эрэлт, нийлүүлэлтийн хүчин зүйлсийн нөлөө нэмэгдэж, инфляц энэ оны 2 дугаар улирлаас өсөхөөр хүлээгдэж байгаа ч суурь инфляц дунд хугацааны зорилтын орчимд хадгалагдах хүлээлт хэвээр байгааг онцолж, Монголбанк цаашид эдийн засгийн сэргэлтийг дэмжинэ гэсэн дохиог зах зээлд өгч, бодлогын хүүгээ бууруулах боломжтой гэж үзэв.

Ингээд Мөнгөний бодлогын хорооны хуралдаанд нийт 6 гишүүн оролцсоноос 5 гишүүн бодлогын хүүг хэвээр хадгалахыг дэмжиж, олонхын саналаар энэ удаад бодлогын хүүг өөрчлөхгүй байхаар шийдвэрлэв.

Хурлын төгсгөлд Төв банкны репо санхүүжилтийн нөхцөлд өөрчлөлт оруулах тухай Мөнгөний бодлогын газар, Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар хамтран боловсруулсан саналыг Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газраас танилцуулж, хэлэлцүүлээ.

Цар тахлын улмаас эдийн засаг, бизнесийн үйл ажиллагаа хумигдаж, санхүүжилтийн хүндрэл үүссэн өнөөгийн нөхцөлд банкуудын зээл олголтыг нэмэгдүүлэх, бизнес эрхлэгчдийн санхүүгийн нөхцлийг зөөлрүүлэх зорилгоор Монголбанкнаас урт хугацаат репо санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлж, 2020 оны 4 дүгээр улирал, 2021 оны 1 дүгээр улиралд банкуудад нийт 430 тэрбум төгрөгийн санхүүжилт олгоод байгааг дурдав. Түүнчлэн, энэхүү санхүүжилт нь бодлогын хүү буурсан нөлөөг саармагжуулж, банкуудын эх үүсвэрийг нэмэгдүүлэх эерэг нөлөө үзүүлж байгааг онцоллоо. Ингээд урт хугацаат репо санхүүжилтийн нөхцөлд өөрчлөлт оруулахтай холбоотой дараах 3 саналыг танилцуулав.

Нэгдүгээрт, Монгол Улсын Засгийн Газраас боловсруулсан Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд олгогдох зээлийн зориулалттай давхцал үүссэнийг арилгаж, репо санхүүжилтийн үр нөлөөг дээшлүүлэх, цаашлаад эдийн засаг, бизнесийн идэвхжилийг дэмжих зорилгоор хамрагдах салбарыг боловсруулах, үйлчилгээ, бөөний болон жижиглэн худалдааны салбараар өргөтгөх саналыг гаргав. Тус салбаруудыг сонгохдоо өөр хөтөлбөрт хамрагдсан эсэх, санхүүжилтийн шаардлага, эдийн засгийн өсөлтөд үзүүлэх хувь нэмэр, ажлын байр хадгалах болон бий болгох чадамж зэрэг үзүүлэлтүүдийг тооцсоны үндсэн дээр сонгосныг тайлбарлалаа. Хоёрдугаарт, нэг зээлдэгчид олгох зээлийн дээд хэмжээг зээлдэгчийн

тархалтад үндэслэн 3 хүртэлх тэрбум төгрөгт хэвээр үлдээх саналыг гаргав. Гуравдугаарт, репо санхүүжилтэд хамрагдах салбарыг өргөтгөсөнтэй холбоотойгоор 2021 оны 2 дугаар улиралд олгох санхүүжилтийн нэмэлт хэмжээг 350 тэрбум төгрөгөөр тогтоох санал гаргасныг МБХ-ны гишүүд хэлэлцлээ.

Гишүүдийн хувьд тус санхүүжилт нь эдийн засгийн сэргэлтийг дэмжих, банкны салбарын тогтвортой байдлыг хадгалахад эерэг нөлөөтэйг онцлоод хамрагдах салбарыг өргөтгөх, үүнтэй уялдуулан санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх саналыг дэмжихээ илэрхийлэв. Цаашлаад зээлдэгчийн өрийн дарамтыг багасгах зорилгоор санхүүжилтийн хүүг бууруулах боломж бий эсэх талаар хэлэлцэж, зээлдэгчдийн төлөх хүүг 10 хувиас хэтрэхгүй байхаар холбогдох бодлогын хэрэгслүүдэд өөрчлөлт оруулах нь зүйтэй гэсэн нэгдсэн байр суурьт хүрлээ.

Ийнхүү МБХ-ны гишүүд Монголбанкнаас банкинд олгох урт хугацаат репо санхүүжилтийн хэмжээг 2021 оны 2 дугаар улиралд 350 хүртэлх тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, хамрах хүрээг өргөтгөх, зээлдэгчийн төлөх хүүг 10 хувиас хэтрүүлэхгүй байхаар тус тус шийдвэрлэв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн ээлжит хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв болон гадаад, дотоод орчны төлөв байдал, эрсдэлийг харгалзан үзээд санхүүгийн нөхцөлийг үргэлжлүүлэн зөөлрүүлэх зорилгоор:

1. Бодлогын хүүг 6 хувьд хэвээр хадгалах;
2. Урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслээр 2021 оны 2 дугаар улиралд 350 хүртэлх тэрбум төгрөгийг олгох шийдвэрийг гаргалаа. Уг санхүүжилтийг боловсруулах, үйлчилгээ болон 200-аас дээш ажилчидтай худалдааны салбарын аж, ахуйн нэгжүүдийг хамруулахаар өргөтгөв.